

Дундговь аймаг дахь
Төрийн аудитын газар



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ,
ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТ, ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ, ХАДГАЛАЛТ,
ХАМГААЛАЛТЫН ҮР АШИГ”-Т ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН
АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДУА-2024/36-ШТА-ГА/

Дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох

Утас: 70592439

Аудитын менежер Т.Оюун-Эрдэнэ

Утас: 70592225

Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

Ахлах аудитор Ч.Бэрхсайхан

Ахлах аудитор Т.Батсайхан

Аудитор Б.Гантуяа

Аудитор Л.Уранбилэг

Аудитор О.Баярсайхан

Утас: 70593208

Тайланг бэлтгэсэн:	Аудитын тайланг баталгаажуулах тухай	3
Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	Товчилсон үгс	4
Дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	5-7
Аудитын менежер Т.Оюун-Эрдэнэ	Дүрслэлийн товьёг	
Ахлах аудитор Ч.Бэрхсайхан	<u>БҮЛЭГ 1. Орон нутгийн хөрөнгө бэлтгэх, бүртгэх, данснаас хасаж, акталж үстгах үйл ажиллагааг хууль журмын хүрээнд оновчтой зохион байгуулахгүй байна.</u>	8
Т.Батсайхан	<i>1.1 Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгийн эрэлт хэрэгцээний судалгааг гаргаж, нэгтгэн эрэмбэлдэггүй, хөрөнгө оруулалт, төсвийн төлөвлөлтөд ОНӨГ-ын оролцоог хангадаггүй, хөрөнгийн хуваарилалт оновчтой бус байна.</i>	8-16
Аудитор Л.Уранбилэг	<i>1.2. Орон нутгийн өмчийн хөрөнгийг актлах, данснаас хасах шалгуур үзүүлэлт байхгүй, дуудлагын худалдаагаар худалдах үндсэн хөрөнгийн үнэ хаялцах доод хязгаарыг дээд газраас баталсан журамд нийцүүлэн батлаагүй байна.</i>	16-22
Б.Гантуяа	<u>БҮЛЭГ 2 Орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт мүү, хөрөнгө үр ашиггүй байна.</u>	22
О.Баярсайхан	<i>2.1 Дутагдалтай болон илүүдэлтэй хөрөнгийн судалгааг гаргаж, илүүдэлтэй хөрөнгийг дутагдалтай байгууллагад шилжүүлэх, ашиглалтыг сайжруулах арга хэмжээ аваагүй байна.</i>	22-26
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70593208 дугаарын утас, 70593208 дугаарын факсаар харилцана уу.	<i>2.2 Өмч хамгаалах зөвлөлүүд чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй, хөрөнгийн хадгалалт хамгаалалт хангалтгүй, дутагдаж гэмтсэн хөрөнгүүдийг хууль журмын дагуу шийдвэрлээгүй, эзэнгүйдсэн байна.</i>	26-32
ХАЯГ:	Дүгнэлт	32
Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 213 тоот	Зөвлөмж	33-34
	Шалгагдагч байгууллагын санал, тайлбар	35
	Хавсралт	36-44
2024 оны 9 дүгээр сар		


ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2024 оны 09 сарын 19 өдөр



Дугаар А/25

Мэдээлэл

Аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 20 дугаар зүйлийн 20.5, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын “Эрх шилжүүлэх тухай” 2023 оны А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх”-ийн 1.1, 1.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 9, 19 дүгээр зүйлийн 19.3 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Орон нутгийн өмчийн харилцаатай холбоотой хууль, журмын хэрэгжилт, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын үр ашиг”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан /ДУА-2024/36-ШТА-ГА/-г нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Гүйцэтгэлийн аудитын тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Орон нутгийн өмчийн газарт тус тус хүргүүлсүгэй.
3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулан, үр дүнгийн талаар 2025 оны 9 дүгээр сарын 10-ны дотор Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг Дундговь аймгийн Засаг даргын орлогч /М.Анхбаяр/, аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /С.Хулан/ нарт зөвлөсүгэй.
4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон 2025 оны 4 дүгээр улиралд танилцуулахыг Аудитын хоёрдугаар нэгжийн ахлах аудитор /Ч.Бэрхсайхан/-д үүрэг болгосугай.


Р.МӨНХТОГТОХ


ТОВЧИЛСОН ҮГС	
ЛАНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
АДБОУБ	Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллага
АЗДТГ	Аймгийн Засаг даргын Тамгын газар
АИТХТ	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид
АЗД	Аймгийн Засаг дарга
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНТ	Орон нутгийн төсөв
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УТ	Улсын төсөв
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ГИЦС	Говийн ирээдүй цогцолбор сургууль
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ӨХЗ	Өмч хамгаалах зөвлөл
ЭМТ	Эрүүл мэндийн төв
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

<p>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:</p>	<p>Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/100 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2024 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аудитыг хийж гүйцэтгэлээ.</p>
<p>Аудитын зорилго, зорилт:</p>	<p>“Орон нутгийн өмчийн харилцаатай холбоотой хууль, журмын хэрэгжилт, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын үр ашиг”-д гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.</p> <p>Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none">Орон нутгийн өмчийн хөрөнгө бэлтгэх, актлах, данснаас хасах үйл ажиллагаа хууль журмын дагуу оновчтой зохион байгуулсан эсэх;Орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хамгаалалт үр ашигтай эсэх.
<p>Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:</p>	<p>Аудитад асуудлын шинжилгээний асуултын дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүйтэй холбоотой дараах хууль, эрх зүйн актын холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон ашигласан.</p> <ul style="list-style-type: none">Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2017 оны 09 дүгээр сарын 19-ны өдрийн 51-р тогтоолын 1-р хавсралтаар батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийн дуудлагын худалдааг зохион байгуулах журам”;Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2020 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 07 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өөрийн өмчийн түрээсийн төлбөрийн жишиг үнэ”;Аймгийн ИТХ-ын 2020 оны 01 дүгээр сарын 24-ны 06-р тогтоолын 2-р хавсралтаар батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээд болон сумын өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны журам”;Аймгийн ИТХ-ын 2022 оны 02 дугаар сарын 15-ны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”;Аймгийн ИТХ-ын 2020 оны 01 дүгээр сарын 24-ны 06-р тогтоолоор батлагдсан “Өмч хамгаалах байнгын зөвлөлд нэмэлт өөрчлөлт оруулах тухай”;Монгол Улсын Сангийн сайдын 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 102 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”;

<p>Аудитын хамарсан хүрээ:</p>	<ul style="list-style-type: none"> ▪ Холбогдох бусад хууль, дүрэм, журам
<p>Аудитын арга зүй:</p>	<p>Аудитад аймгийн ИТХ, ЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, ОНӨГ болон 15 сумын орон нутгийн өмчийн хадгалалт, хамгаалалт, эзэмшилтийн тоон мэдээ, үйл ажиллагаа, орон нутгийн эд хөрөнгийн бүртгэл, арга хэмжээ, илүүдэлтэй болон ашиглалтгүй хөрөнгийн мэдээ тайлан, судалгааг хамрууллаа.</p> <p>Аудитыг АДБООУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБООУС-100, АДБООУС-300, АДБООУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам (2020 он), Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал (2020 он)-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.</p>
<p>Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа</p>	<p>Аудитыг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох хянан удирдаж, ахлах аудитор Ч.Бэрхсайхан, Т.Батсайхан, аудитор Л.Уранбилэг, О.Баярсайхан, Б.Гантуяа нар батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2024 оны 03 сарын 22-ны өдрөөс 07 сарын 05-ны хооронд хийж гүйцэтгэлээ.</p>
<p>Үндсэн мэдээлэл</p>	<p>Орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, захиран зарцуулалтад хяналт тавих, орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдэд компанийн засаглал, өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллагыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2000 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 4 дүгээр тогтоолоор “Орон нутгийн өмчийн алба” нэртэйгээр аймгийн ИТХ-ын дэргэд байгуулж байсан бол 2014 оноос аймгийн ИТХ-ын “Төсөв санхүү, үйлдвэрлэл өмчийн харилцааны хэлтэс” нэртэйгээр өөрчлөн байгуулсан байна. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 09 дүгээр тогтоол, Аймгийн Засаг даргын 2016 оны А/390 тоот захирамжаар аймгийн Орон нутгийн өмчийн алба нь Худалдан авах ажиллагааны албатай нэгдэн ОНӨГ болж өөрчлөн байгуулагдсан. Аймгийн Засаг даргын 2023 оны А/664 дугаар захирамжаар бүтцэд өөрчлөлт орж ОНӨГ нь худалдан авах ажиллагааны газраас тусдаа үйл ажиллагаа явуулж байна. ОНӨГ нь бүтцийн хувьд газрын дарга, өмчийн бүртгэл, ашиглалт хариуцсан ахлах мэргэжилтэн, хөрөнгийн бүртгэл, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн, өмчийн ашиглалт, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн, хууль, хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн, нягтлан бодогч гэсэн бүтцээр 6 орон тоотой байхаар баталснаас 5 орон тоотой ажиллаж байна.</p>

Дундговь аймгийн хэмжээнд нийт орон нутгийн өмчит 143 байгууллага байгаагаас төрийн байгууллага 125, орон нутгийн өмчит үйлдвэрийн газар 18 байна.

Орон нутгийн өмчит 143 хуулийн этгээдийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 226,048.1 сая төгрөгийн анхны өртөгтэй 42,562.7 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна. Уг үндсэн хөрөнгийн 64.8 хувийг барилга байгууламж, 12.1 хувийг машин тоног төхөөрөмж, 3.8 хувийг тээврийн хэрэгсэл, 3.4 хувийг тавилга эд хогшил, 0.4 хувийг түүх соёлын дурсгалт зүйлс, 0.3 хувийг ном, 0.2 хувийг биет бус хөрөнгө, 1.0 хувийг дуусаагүй барилга, 0.9 хувийг бусад үндсэн хөрөнгө, 13.1 хувийг газар эзэлж байна.

Хөрөнгийн 26.4 хувь боловсрол, 25.0 хувь төрийн захиргаа, 24.6 хувь ОНӨААТҮГ, 12.9 хувь эрүүл мэнд, 6.7 хувь спорт, соёл, урлаг, 2.5 хувь хууль, хяналт, 2.0 хувь бусад салбарт бүртгэлтэй байна.

Эх сурвалж: Орон нутгийн өмчийн газрын мэдээгээр



БҮЛЭГ 1. Орон нутгийн өмчийн хөрөнгө бэлтгэх, бүртгэх, данснаас хасаж, акталж үстгах үйл ажиллагааг хууль, журмын хүрээнд оновчтой зохион байгуулахгүй байна.

1.1 Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгийн эрэлт хэрэгцээний судалгааг гаргаж, нэгтгэн эрэмбэлдэггүй, хөрөнгө оруулалт, төсвийн төлөвлөлтөд ОНӨГ-ын оролцоог хангадаггүйгээс хөрөнгийн хуваарилалт оновчтой бус байна.

Дундговь аймгийн хэмжээнд 2023 оны жилийн эцсийн байдлаар 141 орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дансанд 254.5 тэрбум төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь аудитаар баталгаажсан төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаас 129.9 тэрбум төгрөгөөр илүү байна. Энэ нь улсын төсвийн байгууллагуудын үндсэн хөрөнгийг ОНӨГ бүртгэж ТӨБЗГ-г тайлагнадаг бол ТЕЗ-ийн санхүүгийн тайланд тусгадаггүйтэй холбоотой байна.

ОНӨГ-ын ашигладаг тооллогын системээр гаргадаг үндсэн хөрөнгийн хөдлөлт өөрчлөлтийн тайлан нь жил бүрийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаас зөрүүтэй ба 2020 оны үлдэгдэл 17.5 тэрбум, 2021 оны үлдэгдэл 18.3 тэрбум, 2022 оны үлдэгдэл 112.2 тэрбум төгрөгийн зөрүүтэй байна. Үүнээс харахад ОНӨГ, СТСХ нь тооцоо нийлж тулган баталгаажуулдаггүй, үйл ажиллагааны уялдаа холбоо муу байна. Иймд дээрх онуудын хөрөнгийн бүртгэлийн зөрүүг арилгаж, тооцоо нийлж баталгаажуулах, цаашид байгууллага хоорондын уялдаа холбоог сайжруулан, хамтран ажиллах шаардлагатай байна.

ОНӨГ нь орон нутгийн өмчит хуулийн этгээдэд нэн шаардлагатай хөрөнгийн хэрэгцээ, эрэмбэ дарааллын талаар гаргаж нэгтгэсэн тооцоо судалгаа, тоон мэдээлэл байхгүй, ашиглаж байгаа программ нь хөрөнгийн мэдээллийг дансны төрөл, байршил, үйл ажиллагааны салбар зэрэг үзүүлэлтээр боловсруулдаггүй байна. Энэ нь сум, байгууллагын хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, хөрөнгийн хуваарилахтай холбоотой судалгаа, дүн шинжилгээ хийхэд хүндрэлтэй байна.

Сүүлийн 2 жилийн байдлаар бүртгэлтэй үндсэн хөрөнгийг аймаг, сумдаар авч үзвэл:


Хүснэгт-1 /сая.төг/

Аймаг, сумын нэр	2022 он	2023 он	Өөрчлөлт
АЗД-ын харьяа байгууллага	51,792.3	54,887.1	6.0%
Адаацаг	5,144.2	8,158.7	58.6%
Баянжаргалан	5,740.5	6,022.3	4.9%
Говь-Угтаал	4,518.2	5,151.5	14.0%
Гурвансайхан	11,882.8	13,298.7	11.9%
Дэлгэрхангай	7,895.9	8,604.5	8.9%
Дэлгэрцогт	5,354.6	6,180.0	15.4%
Дэрэн	7,023.6	7,432.3	5.8%
Луус	3,693.0	4,379.2	18.6%
Өлзийт	10,332.3	11,275.3	9.1%
Өндөршил	6,285.7	7,096.3	12.9%
Сайнцагаан	23,140.3	26,091.7	12.7%
Сайхан-Овоо	7,787.5	12,819.6	64.6%
Хулд	5,706.5	7,296.5	27.9%
Цагаандэлгэр	2,697.4	3,058.0	13.4%
Эрдэнэдалай	11,541.8	15,083.2	30.7%

Эх сурвалж: Орон нутгийн өмчийн газар

Хүснэгтээс харахад Сайхан-Овоо сум 64.6 хувь, Адаацаг сум 58.6 хувь, Эрдэнэдалай сум 30.7 хувиар өссөн бол Баянжаргалан, Дэрэн сумын хөрөнгө 4.9-5.8 хувиар өсжээ.


Хөрөнгийн хэмжээг үйл ажиллагааны салбараар авч үзвэл:



Эх сурвалж: Орон нутгийн өмчийн газар

Графикаас харахад боловсролын болон төрийн захиргааны байгууллагад хамгийн их хөрөнгө бүртгэлтэй байна. Спорт, соёл урлагийн салбарын хөрөнгө хамгийн их буюу 20.5 хувиар, эрүүл мэндийн салбарын хөрөнгө 19.1 хувиар, боловсролын салбар 17.4 хувиар, төр захиргааны салбарын хөрөнгө 13.0 хувиар өссөн байна.

Сумдын барилгаас бусад үндсэн хөрөнгийг 2023 оны байдлаар хүн амын тоотой харьцуулж үзвэл 1 хүнд Гурвансайхан сум 3.1 сая, Өлзийт сум 2.8 сая, Сайхан-Овоо сум 2.3 сая, Өндөршил сум 2.3 сая төгрөг буюу хамгийн өндөр, Сайнцагаан сум 0.6сая, Эрдэнэдалай сум 0.9 сая төгрөгийн хөрөнгө ноогдож байгаа нь хамгийн бага байна.



Хөрөнгийн өөрчлөлтийг харахад 1 хүнд ноогдох хөрөнгө ихтэй Гурвансайхан, Өлзийт, Сайхан-Овоо сумдын хөрөнгө илүү нэмэгдсэн бол Сайнцагаан, Эрдэнэдалай сумдын хөрөнгө харьцангуй бага боловч өсөлт мөн бага байна.

Сумдын хөрөнгийг 2023 оны байдлаар төрийн албан хаагчдын тоонд харьцуулан үзвэл 1 төрийн албан хаагчид ноогдох хөрөнгө Өлзийт суманд 68.7 сая, Гурвансайхан суманд 61.0 сая,

Сайхан-Овоо суманд 49.4 сая, Өндөршил суманд 35.8 сая төгрөг буюу хамгийн их байгаа бол Сайнцагаан суманд хамгийн бага буюу 14.6 сая төгрөг ноогдож байна. Харин бусад сумдад 24.1-30.0 сая төгрөг байна.

График-3



Графикаас харахад 1 төрийн албан хаагчид ноогдох хөрөнгө ихтэй Өлзийт, Гурвансайхан, Сайхан-Овоо, Өндөршил сумдын хөрөнгө илүү нэмэгдсэн байна. Энэ нь хөрөнгийн хуваарилалт оновчтой бус, тооцоо судалгаа хийдэггүйтэй холбоотой байна.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 17 ерөнхий боловсролын сургуулийн ашиглаж байгаа 19 барилгын нийт суурилагдсан хүчин чадал 6,640 хүүхэд хүлээн авах боломжтойгоос 6,765 хүүхэд хүлээн авч хүчин чадал ашиглалт 101.9 хувь буюу ачаалал хэтрэлт 1.9 хувь байна.

“Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн” сэдэвт 2020 онд хийгдсэн гүйцэтгэлийн аудитын тайлангаар Сайнцагаан сумын Говийн ирээдүй цогцолбор сургууль, Хүмүүнлэг сургуулийн хичээлийн байрыг шинээр барих хэрэгцээ шаардлагаар хамгийн эхэнд эрэмбэлэгдсэн, мэргэжлийн байгууллагын дүгнэлт гарч, шинээр баригдаж байгаа тул дээрх тооцоололд ороогүй болно. Цэгц билиг сургуулийн барилга нь анх дотуур байрны зориулалттай баригдсан ба хичээлийн байрны зориулалтаар ашигласнаас хойш хүчин чадлыг шинэчлэн тогтоогоогүй тул хүчин чадал ашиглалтын тооцоолол хийх боломжгүй байна.

График-4

Өлзийт, Луус, Баянжаргалан сумдын цэцэрлэгийн ашиглагдаагүй хүчин чадал 20.0-48.6 хувьтай байна.

Сургуулиудын хичээлийн байрны зориулалтаар ашиглаж байгаа 20 барилгаас 9 нь 40-өөс дээш жил ашиглаж байгаа насжилт өндөр барилга байна.

График-6



Хамгийн олон жил ашиглаж байгаа Эрдэнэдалай сумын сургуулийн хичээлийн 2 дугаар байрыг 72 жил ашиглаж, ашиглалтын хугацаа дууссан бол Сайхан-Овоо, Дэрэн, Дэлгэрхангай, Гурвансайхан, Өндөршил, Сайнцагаан сумын Мандал сургуулийн барилга насжилт бага шинэ барилгууд байна.

Цэцэрлэгийн хувьд 26 барилга ашиглаж байгаагаас Говь-Угтаал сумын цэцэрлэгийн барилга 60 жил ашигласан бол 40-өөс дээш жилийн насжилттай 8 цэцэрлэг, 10-аас доош жилийн ашиглаж байгаа 9 цэцэрлэг байна.

График-7



ОНӨГ нь барилгын ашиглалт, насжилт, хүчин чадлын ашиглалтын талаар тооцоо судалгаа хийдэггүйгээс хөрөнгө оруулалт оновчтой бус хуваарилагдах эрсдэлтэй байна. Иймд цаашид барилгын насжилт, хүчин чадлын ашиглалт, хэрэгцээ шаардлагыг харгалзан хөрөнгө оруулалтыг оновчтой хуваарилахад анхаарах нь зүйтэй байна.

Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2021-2023 онд Адаацаг, Говь-Угтаал, Өлзийт сумын сургуулийн барилгад, Дэлгэрхангай, Дэлгэрцогт, Дэрэн, Өлзийт, Эрдэнэдалай, Сайнцагаан сумын 4, 6 дугаар цэцэрлэгүүдэд их засвар хийгдсэн байна. Засвар хийгдсэн 10 барилгын 8 нь 30-аас дээш жил ашигласан бол Дэлгэрхангай, Дэрэн сумын цэцэрлэг засвар хийх үед тус бүр 7 жил ашигласан барилга байсан байна. Энэ хөрөнгө оруулалтын арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл зарим талаар оновчтой бус, чанаргүй хийгдэж байгааг харуулж байна.